



МОНГОЛ УЛСЫН
СОЁЛЫН САЙДЫН ТУШААЛ

2022 оны 04 сарын 28 өдөр

Дугаар А/116

Улаанбаатар хот

Дүрэм, бүтэц шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Соёлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэг, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсэг, “Соёлын өвийн үндэсний төв байгуулах тухай” Засгийн газрын 2017 оны 239 дугаар тогтоолын 2.2-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Соёлын өвийн үндэсний төвийн дүрэм”-ийг 1 дүгээр, Зохион байгуулалтын бүтцийг 2 дугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2. Батлагдсан бүтэц, дүрмийг мөрдөн, ажлын байрыг оновчтой зохион байгуулж ажиллахыг Соёлын өвийн үндэсний төвийн захирал (Г.Энхбат)-д даалгасугай.

3. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан “Дүрэм, бүтэц шинэчлэн батлах тухай” Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2017 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн А/295 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.


САЙД



Ч.НОМИН

14190018310

Соёлын сайдын 2022 оны 04 дүгээр
сарын 28-ны өдрийн А/116 дугаар
тушаалын 1 дүгээр хавсралт



СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Соёлын өвийн үндэсний төв нь (цаашид “Үндэсний төв” гэх) Монгол Улсын соёлын өвийг бүртгэх, судлах, хадгалах, сэргээн засварлах, авран хамгаалах, сурталчлах чиг үүрэг бүхий төрийн өмчит, соёл, эрдэм шинжилгээний байгууллага мөн.

1.2. Үндэсний төв нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Соёлын тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, хэлэлцээр, энэхүү дүрмийг мөрдөнө.

1.3. Үндэсний төв нь өөрийн бэлгэдэлтэй байна. Үндэсний төв нь үйл ажиллагаандаа албан хэрэг хөтлөлтийн хэвлэмэл хуудас, тэмдэг хэрэглэнэ.

1.4. Үндэсний төвийн оноосон нэр нь:

Монгол хэлээр: Соёлын өвийн үндэсний төв,

Англи хэлээр: National Center for Cultural Heritage.

Товчилсон нэр нь: СӨҮТ байна.

Хоёр. Үйл ажиллагааны үндсэн чиглэл

2.1. Үндэсний төв нь дараах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

2.1.1. Соёлын өвийг бүртгэн мэдээлэх, сурталчлах чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд:

-соёлын өвийг эрэн сурвалжлах, таньж тогтоох, тодорхойлох;

-соёлын өвийг бүртгэх, баримтжуулж улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэх;

-хууль тогтоомжид заасны дагуу соёлын өвийн бүртгэл, тайлан мэдээг хүлээн авч, улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд хадгалах;

-соёлын өвийг таньж тогтоох, тодорхойлох, бүртгэх, баримтжуулах, хадгалах, сурталчлах талаар арга зүйн заавар зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулах;

-шат шатны бүртгэл, мэдээллийн санг арга зүйн удирдлагаар хангах, үйл ажиллагаанд нь хяналт тавих;

-соёлын өвийн мэдээллээр гэрэл зургийн цомог, сурталчилгааны хялбаршуулсан бүтээл гаргах, өмчлөгч, эзэмшигчийн зөвшөөрөл, холбогдох

журмын дагуу зурагт хуудас, хэвлүүлэх, баримтат кино, медиа бүтээл хийж олон нийтэд сурталчлах;

-Улсын Их Хурал, Засгийн газар, соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төрийн захиргааны байгууллагыг соёлын өвийн лавлагаа, мэдээллээр шуурхай хангах, иргэн, хуулийн этгээдийн хүсэлтийг үндэслэн соёлын өвийн лавлагаа мэдээллийг гаргаж өгөх;

-гадаад улс оронд хадгалагдаж байгаа монголын түүхэнд холбогдох соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэх;

-соёлын өвийн ангилал, төрөл зүйлээр статистик мэдээлэл гаргах, тоо бүртгэл хөтлөх.

2.1.2. Соёлын өвийг авран хамгаалах чиг үүргийн хүрээнд:

-соёлын өвийг авран хамгаалах арга хэмжээг шуурхай зохион байгуулах;

-аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс палеонтологи, археологийн авран хамгаалах хайгуул, малтлага судалгааны ажил хийлгэх захиалгыг хүлээн авч, холбогдох эрдэм шинжилгээний байгууллагаар гүйцэтгүүлэх ажлыг улсын хэмжээнд зохицуулах;

-аж ахуйн нэгж байгууллага, иргэний аж ахуйн үйл ажиллагаа соёлын өвд нөлөөлөх байдлыг судалж дүгнэлт гаргах;

-үндэсний хэмжээнд соёлын өвд сөрөг нөлөөлөх байгалийн гамшиг эрсдэл болон нийгмийн хүчин зүйлийн эрсдэлийн төрөлжсөн судалгаа, үнэлгээг холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран хийх.

2.1.3. Соёлын биет өвийг судлах, сэргээн засварлах чиг үүргийн хүрээнд:

-соёлын биет өвийн материал, технологи, арга ажиллагаанд судалгаа хийж, уламжлалт мэдлэг арга ухааныг орчин үеийн шинжлэх ухааны олон талт дэвшилтэт арга, технологитой хослуулан, олон улсын зарчим, хэм хэмжээний дагуу хадгалалт хамгаалалтын судалгааг зохион байгуулах;

-соёлын биет өвийг бэхжүүлж, сэргээн засварлах арга зүйн судалгаа явуулах;

-түүх, соёлын дурсгалт зүйл, үл хөдлөх дурсгалыг сэргээн засварлах;

-соёлын биет өвийг хадгалах, сэргээн засварлах талаар холбогдох аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд заавар зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулах;

-соёлын биет өвийг хамгаалах, сэргээн засварлах талаар санал боловсруулж дээд шатны байгууллагад хүргүүлэх;

-палеонтологи, археологийн олдвор болон бусад дурсгалт зүйлийг шаардлага хангасан лаборатори, өрөө тасалгаанд түр хадгалах.

2.1.4. Үндэсний төв нь Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 20.3-т зааснаас бусад дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

-дээд шатны байгууллагаас өгсөн үүрэг даалгавар, даалгасан ажлыг шуурхай хэрэгжүүлж тайлагнах;

-Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ хэлэлцээр, конвенцын хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлэх, хугацаат тайланг бэлтгэх;

-Дэлхийн өвд бүртгэгдсэн соёлын өвийн хадгалалт, хамгаалалтын менежментийг хэрэгжүүлэх, хугацаат тайланг бэлтгэхэд дэмжлэг үзүүлэх;

-соёлын өвийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх талаар бүх талын арга хэмжээг зохион байгуулах;

-соёлын өвийг бүртгэх, судлах, хадгалах, сэргээн засварлах, сурталчлах чиглэлээр олон улсын байгууллага, гадаадын байгууллагатай хамтарсан төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх;

-Улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд бүртгэгдсэн соёлын өв болон соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчид гэрчилгээ олгох ажлыг зохион байгуулах;

Гурав. Үндэсний төвийн удирдлага, зохион байгуулалтын бүтэц

3.1. Үндэсний төвийн өдөр тутмын үйл ажиллагааг захирал удирдана.

3.2. Үндэсний төвийн захирлыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн томилж, чөлөөлнө.

3.3. Үндэсний төвийн захирал соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд ажлаа тайлагнах бөгөөд дор дурдсан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

3.1.1. хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын болон холбогдох бусад шийдвэрийг биелүүлэх;

3.1.2. батлагдсан төсвийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зориулалтын дагуу үр ашигтай захиран зарцуулах;

3.1.3. батлагдсан цалингийн сан, бүтэц, орон тоондоо багтаан Үндэсний төвийн ажилтныг томилох, хууль болон гэрээнд заасан үндэслэлээр чөлөөлөх, гэрээ байгуулах;

3.1.4. байгууллагыг хөгжүүлэх урт, дунд, богино хугацааны хөтөлбөр, стратегийн төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх;

3.1.5. байгууллагын өмч хөрөнгийг хамгаалах, зохистой ашиглах талаар арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

3.1.6. хууль тогтоомжид нийцүүлэн байгууллагын хэмжээнд мөрдөх дүрэм, журмыг батлан мөрдүүлэх;

3.1.7. байгууллагын хүний нөөцийн чадавхыг дээшдүүлэх, тасралтгүй хөгжих боломжоор хангах;

3.1.8. ажилтан, албан хаагчдын эвлэлдэн нэгдэх эрхийг хүндэтгэж, үйлдвэрчний эвлэлийн байгууллагатай хамтран ажиллах;

3.1.9. захирал өөрийн эрх хэмжээний хүрээнд хэлцэл хийх, гэрээ байгуулах, байгууллагыг гадаад дотоодод төлөөлөх зэргээр үндэсний төвийн нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаа явуулах;

3.1.10. хууль тогтоомжид заасан бусад эрх үүрэг.

3.4. Захирлыг эзгүй үед байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг Захиргаа, удирдлагын газрын дарга мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллана.

3.5. Үндэсний төвийн зохион байгуулалтын бүтэц нь Захиргаа, удирдлагын нэгж, Бүртгэл, мэдээллийн нэгж, Хадгалалт хамгаалалт, технологи судалгааны нэгж, Сэргээн засварлах нэгж, Түүхэн дурсгалт барилга, архитектурын дурсгалыг хамгаалах нэгж, Авран хамгаалах, эрсдэлийн судалгааны нэгж, Мэдээллийн технологийн нэгжтэй байна.

3.6. Захирлын дэргэд байгууллагын дотоод үйл ажиллагаатай холбогдсон асуудлыг хэлэлцэж санал дүгнэлт гарган захиралд зөвлөх үүрэгтэй Захиргааны зөвлөл ажиллана.

3.7. Үндэсний төвийн зохион байгуулалтын бүтцийн нэгжийн эрхлэх асуудалд эрдэм судлал, мэргэжлийн дэмжлэг туслалцаа үзүүлэх үүрэгтэй орон тооны бус Эрдмийн зөвлөл, Соёлын биет өвийг таньж тогтоох шинжээчийн зөвлөл, Соёлын биет бус өв, өвлөн уламжлагчийг таньж тогтоох шинжээчийн зөвлөл тус тус ажиллана.

3.8. Захиргааны зөвлөл болон шинжээчийн зөвлөлийн ажиллах журмыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн захирал баталж мөрдүүлнэ.

3.9. Үндэсний төв нь ажлын хэрэгцээний номын сан, сургалтын танхим, бага театр, гэрэл зураг, дүрс бичлэгийн студитэй байна.

Дөрөв. Үндэсний төвийн эд хөрөнгө, санхүү

4.1. Үндэсний төвийн хөрөнгө нь байгууллагын үндсэн хөрөнгөд тусгагдсан барилга, тоног төхөөрөмж, эд хогшил, материалаас бүрдэнэ.

4.2. Үндэсний төвийн санхүүжилт дараах эх үүсвэрээс бүрдэнэ.

4.2.1. улсын төсөв;


4.2.2. орон нутгийн төсөв;

4.2.3. аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн хандив тусламж;

4.2.4. олон улсын байгууллага, гадаадын байгууллагын хөнгөлөлттэй зээл, хамтран хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөр;

4.2.5. хууль тогтоомжоор зөвшөөрөгдсөн бусад эх үүсвэр.

4.3. Үндэсний төв нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу зохих бүртгэлүүдийг хөтөлж, санхүүгийн тайлан тэнцлийг гарган баталгаажуулна.



Соёлын сайдын 2022 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн А/116 дугаар тушаалын 2 дугаар хавсралт

СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЭЦ

